



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/358

Чингис хот

Арга хэмжээнд оролцох,
орон нутагтаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ерөнхий сайдын 2021 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 163 дугаар захирамж, Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны "Махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тухай" А/319 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд "Махны өргөтгөсөн худалдаа" зохион байгуулахад оролцох сумдын нэр, худалдах байршил, нийлүүлэх махны хэмжээг нэгдүгээр хавсралтаар, аймгийн хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулахад оролцох сумдын нэр худалдах байршил, нийлүүлэх махны хэмжээг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Өргөтгөсөн худалдааны үеэр оролцогч иргэн, аж ахуйн нэгжүүдийн худалдааны (зориулалтын хувцас, хэрэгсэл, гар ариутгагч, баталгаажсан жин) бэлэн байдлыг хангуулж, арга хэмжээний хугацаанд тасралтгүй махыг нийлүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан), сумдын Засаг дарга нарт, малын цахим гэрчилгээг олгож, малын гарал үүсэл, мах борлуулж буй орчны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Сүнгээ) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012548

Аймгийн Засаг даргын 2021 оны
 11 дүгээр сарын 23 өдрийн А/с/с/8
 захирамжийн хавсралт

УЛААНБААТАР ХОТОД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ МАХНЫ
 ӨРГӨТГӨСӨН ХУДАЛДААНД СУМДААС НИЙЛҮҮЛЭХ МАХНЫ ХЭМЖЭЭ

№	Сум	Нийлүүлэх махны хэмжээ, тн	Махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулагдах худалдааны төвийн байршил, хугацаа
1	Галшар	16.4	Улаанбаатар хот Төв цэнгэлдэх хүрээлэн 2021.11.25-2021.12.02
2	Баянхутаг	23.5	
3	Баянмөнх	10.2	
4	Дархан	12.8	
5	Дэлгэрхаан	12.8	
6	Жаргалтхаан	6.9	
7	Цэнхэрмандал	11.1	
8	Өмнөдэлгэр	31.8	
9	Батширээт	3.0	
10	Биндэр	11.8	
11	Баян-Адарга	11.1	
12	Дадал	2.5	
13	Норовлин	10.8	
14	Батноров	19.1	
15	Баян-Овоо	7.4	
16	Мөрөн	9.2	
17	Хэрлэн	26.5	
18	Бор-Өндөр	3.9	
ДҮН		230.8	

**ХЭНТИЙ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ МАХНЫ
 ӨРГӨТГӨСӨН ХУДАЛДААНД СУМДААС НИЙЛҮҮЛЭХ МАХНЫ ХЭМЖЭЭ**

№	Сум	Нийлүүлэх махны хэмжээ, тн	Махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулагдах хугацаа
1	Галшар	9.8	Хэнтий аймгийн төв цэнгэлдэх хүрээлэн 2021.12.04-2021.12.05
2	Баянхутаг	14.1	
3	Баянмөнх	6.1	
4	Дархан	7.7	
5	Дэлгэрхаан	7.7	
6	Жаргалтхаан	4.1	
7	Цэнхэрмандал	6.7	
8	Өмнөдэлгэр	19.1	
9	Батширээт	1.8	
10	Биндэр	7.1	
11	Баян-Адарга	6.7	
12	Дадал	1.5	
13	Норовлин	6.5	
14	Батноров	11.5	
15	Баян-Овоо	4.4	
16	Мөрөн	5.5	
17	Хэрлэн	15.9	
18	Бор-Өндөр	2.3	
ДҮН		138.5	